



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 11 сарын 20 өдөр

Дугаар 525

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 1.а дахь заалт, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.1, 4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Хууль зүй, дотоод хэргийн сайд, Сангийн сайдын 2018 оны А/115/136 дугаар хамтарсан тушаал, Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албаны 2007 оны 27 дугаар тогтоол, Банкны өр барагдуулах газрын 2007 оны 1/521 дүгээр албан бичгийн дагуу татан буугдсан, дампуурсан банкуудын төлбөрт тооцон хураагдсан, нийт 740,119,078.14 (долоон зуун дөчин сая нэг зуун арван есөн мянга далан найман төгрөг арван дөрвөн мөнгө) төгрөгийн үнэлгээ бүхий хавсралтад заасан барилга байгууламжийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Банк, хадгаламж зээлийн хоршоодын төлбөр барагдуулах Ажлын албаны үндсэн хөрөнгийн дансанд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Билгүүн, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга, бригадын генерал Ц.Амгаланбаяр болон тогтоолд заасан байгууллагын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгийг бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Ц.НЯМ-ОСОР

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ГАВАА

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 11 дүгээр сарын 20 -ны өдрийн
525 дугаар тогтоолын хавсралт

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬЯА
БАНК, ХАДГАЛАМЖ ЗЭЭЛИЙН ХОРШООДЫН ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ
АЖЛЫН АЛБАНЫ ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр, байршил	Ашиглалтад орсон он	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Үнэлгээ (төгрөг)
1	Аммиакан хөргөлттэй зоорийн барилга (Хөвсгөл аймаг Мөрөн сум, 7 дугаар баг)	2007	м2	1474	540,119,078.14
2	Амралтын зориулалттай байр (Завхан аймаг, Алдархаан сум, Богдын гол баг)	1988	м2	960	200,000,000.00
	Нийт дүн				740,119,078.14 (долоон зуун дөчин сая нэг зуун арван есөн мянга далан найман төгрөг арван дөрвөн мөнгө)